

Электрон билетийг Интернетийн цахим хуудсаар дамжуулан худалдан авах

Интернетээр дамжуулан борлуулалт хийх нь хэд хэдэн давуу талтай бөгөөд өнөөгийн хурдацтай хөгжлийн үед дараах гол 2 давуу тал нь чухал билээ. Нэгд: худалдан авах энэхүү үйл ажиллагаанд ердөө 5 – 10 минут зарцуулна, Хоёрт: цахим хуудас нь суудлын бололцоотой нислэг тус бүрээр нь санал болгодог.

Агаарын тээврээр зорчих тийз худалдан авахад интернетэд холбогдсон компьютер, хэвлэгч төхөөрөмж болон төлбөрийн Виза болон Мастер картууд байхад хангалалттай билээ.

Цахим хуудсаар дамжуулан билет худалдан авах журам

Билет худалдан авахын тулд дараах 5 үйлдлийг хийнэ.

Аялал хайх

Үйлчлүүлэгч Та МИАТ компанийн цахим хуудас болох www.miat.com – д Захиалга эсвэл нислэгийн шаардлага гэсэн хуудсанд орж нисэх болон очих хот, аялах өдөр, аялах хүний тоо / насанд хүрэгчид, хүүхэд, нялх хүүхэд / г.м захиалга хийхэд хэрэгцээтэй өгөгдөхүүнүүдийг оруулах. Түүнчлэн ямар зэрэглэлээр зорчихоо сонгоно. / Энгийн эсвэл Бизнес /.

Аялал сонгох

Аялал сонгосноор тэр өдрийн боломжит үнийг санал болгоно. Хэрэв таны сонгосон өдөр нислэг байхгүй тохиолдолд өөр өдөр оруулж дахин хайх шаардлагатай. Үүний тулд дараагийн хуудас руу орох бөгөөд ингэснээр Цахим хуудсаар борлуулалт хийх систем нь шинээр өгөгдөхүүнээ оруулахыг санал болгоно. Ингээд хэрэв аялалын үнэ чухал бол танд богино хугацаанд хамгийн бололцоот үнэтэй аялал санал болгоно.

Зорчигчийн мэдээлэл

Энэ хуудас руу орж өөрийн паспортны өгөгдөхүүн болон холбоо барих дугаар оруулах түүнчлэн эндээс үнийн нөхцөл болон янз бүрийн хурамжийн талаар мэдээлэл оруулах болно.

Төлбөрийн өгөгдөхүүн

Энэ хуудсанд орж худалдан авагч та төлбөрийн картны өгөгдөхүүнээ оруулна. Үүнд: дугаар, эзэмшигчийн нэр болон CVC код / кредит картны ар талын дугаар /. Энэхүү өгөгдөхүүнийг Интернет протоколын хамгаалалт бүхий сувгаар дамжих бөгөөд гуравдагч этгээд ямар мэдээлэл авах бололцоогүй хамгаалалттай. Энэ үед худалдан авагч нарт зайлшгүй мэдэх шаардлагатай мэдээлэл мөн “ төлбөрийн болон тээвэрлэлтийн нөхцөл “ – ийг хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай.

Баталгаажуулалт

Билет худалдан авах нийт үнийн дүнг таны картанд блоклоно. Энэхүү суудал захиалгыг хийсэн тухай өгөгдөхүүн болон ялгах тэмдэг зэрэг таны бүртгүүлсэн цахим хаяг руу ирнэ.

Суудлын баталгаажуулалт хийгдсэний дараа 10 – 15 минутын дараа электрон билетний аялалын баримтыг хүлээн авах болно. Үүнийг хэвлэн авч эсвэл нисэх буудлын зорчигч бүртгэл дээр гадаад паспортаа авчиран бүртгүүлнэ. Таны электрон билет нь манай компанийн цахим мэдээллийн баазад хадгалагдах учир гээх эсвэл хулгайд алдах боломжгүй.

Суугчийн талон

Нисэх буудлын бүртгэл дээр үйлчлүүлэгч та паспортоо үзүүлсэнээр суугчийн талон авч нисэхэд бэлэн болно.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл МИАТ компанид хандана уу.

Утас: + 976 (11) 379935 ажлын өдрүүдэд 09.00-16.00

Цахим хаяг: helpdesk@miat.com

VISA болон Master картаас төлбөр хийх


Суудал захиалга хийж дууссаны дараа кредит картаар төлбөр хийхийн тулд www.golomtbank.com цахим хуудас руу шилжин орно. Үйлчлүүлэгчээс Голомт банкаар дамжин хийж буй төлбөр мөн Төлбөрийн системийн сервер болон цааш хийгдэх үйлдлийн явцад төлбөр хийж буй хүний банкн дахь мэдээллийн нууцлалыг Голомт банк нь SSL протоколын дагуу хангана. Мэдээлэл цааш дамжихдаа банкны өндөр хамгаалалт бүхий сүлжээгээр явагдах бөгөөд үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээллийн / банкны өгөгдөхүүн, бүртгэлийн дугаар г.м /боловсруулалт нь картын боловсруулах төвд хийгдэнэ. Иймд МИАТ компани болон гуравдагч этгээд нь үйлчлүүлэгчийн кредит картны тухай болон бусад мэдээллийг тэр тусмаа тухайн үйлчлүүлэгчийн өөр газруудад хийгдсэн төлбөрийн талаар мэдээлэл авах боломжгүй.

Төлбөрийн Виза болон Мастер картаар төлбөр хийх

МИАТ компанийн Интернетийн цахим хуудсаар дамжуулан онгоцны билет худалдан авахад төлбөрийг бүх төрлийн Виза болон Мастер картаар гүйцэтгэж болно.

Та юу мэдэх шаардлагатай вэ

- Таны төлбөрийн картны дугаар
- Төлбөрийн картны хүчинтэй хугацаа он сар
- Виза картны CVV код / Мастер картны CVC код: картны ар талын гарын үсэг зурдаг хэсэг дэх тооны сүүлийн гурван оронтой тоо



Хэрэв таны карт CVC/CVV код байхгүй бол таны карт CNP үйлдэл хийхэд зориулагдаагүй учир банкинд хандаж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Интернетээр худалдан авсан билетийн төлбөрийг буцаах нь

Билет худалдан авсан төлбөрийг МИАТ компани нь зөвхөн төлбөр хийсэн кредит картын данс руу буцаана. Билетийн төлбөрийг буцаахдаа нийт үнийн дүнгээс үйлчилгээний хөлс, тарифын нөхцөлд тусгайлан заасан торгууль зэргийг хасч тооцно.

Билетийн үнийг буцаан авахын тулд helpdesk@miat.com руу хандаж хүсэлт гаргаж, билет худалдан авсан үеийн зарим нэгэн мэдээллийг өгөх шаардлагатай. Билетийн буцаавал зохих үнийг ажлын 7 хоногт буцаан олгоно.